

Эх нь булингартай бол адаг нь булингартай

ХИС-ийн Сэтгүүлчийн хоёрдугаар ангийн оюутан Б.Нандинцэцэг

Би цэцэрлэгийнхээ багшийг нэг их сайн санадаггүй юм. Харин дуу хөгжмийн багш маань сэтгэлд хоногшсон байдаг. Надад сайхан ханддаг, нүдээрээ инээж угтан авдаг тийм л сайхан багш байлаа. Үе үеэс нүдэнд минь инээж байгаа төрх нь үзэгдэнэ. Энэ хүнээс хойш би ийм багштай ер учирсангүй. Ямар багштай учирснаа харин дор өгүүлье.

Хүчирхийлэгч багш

2008 онд ээж минь намайг анх сургуульд оруулахдаа “Миний охин өнөөдөр ингээд хоёр ээжтэй боллоо. Багшийнхаа үгэнд сайн ороорой” гэж захисан юм. Даанч тэр хүн ээж шиг минь байгаагүй юм. Дөнгөж сургуульд хөл тавьж байгаа жаахан би дэвтэр дээрх дүрсээ багш шигээ гоё бичиж чадаагүй юм. Гэтэл нөгөө багш гэдэг эгч чинь гараа атгаж байгаад миний толгой руу хэд хэдэн удаа цохиод авсан. Тэр үеэс л би бүрэг ичимхий, дотогшоогоо болж, хамаагүй юм хэлчихвэл багш минь зодох байх гэдэг айдаст автчихсан. Харин одоо хүүхдийн сайн муу яваа нь багшаас ихээхэн шалтгаалдаг гэдгийг би ойлгодог болсон.

“Би ХУД-ийн 4-р дүгээр сургуулийг төгссөн. Манай бага ангийн багш Б.Ариунаа сайн хүүхдүүдийг улаан цайм дэмждэг. Биднийг тоо муу бодож байна хэмээн таягаараа цохиж, хумсалж чимхдэг байсан. Тэгээд маш урт улаан хумсаа гарт зоож, хэрэв хумсыг минь хугалвал төлж өгөөрэй хэмээн уурлаж загнадагсан. Нэг найзыг маань таягаараа цохиж байгаад хугалаад хаячихсан. Таягаа хугартал цохисон гэхээр сэтгэл эмзэглэж байна” гэж ХИС-ийн Сэтгүүлчийн 2-р ангийн оюутан А.Номин-Эрдэнэ хэлсэн юм.

Сургууль хүүхдийн хувьд аюулгүй бөгөөд сурч боловсрох эрхийг нь бүрэн хангасан газар байх ёстой. Бидний аюулгүй гэж итгэсэн газарт хүүхдүүд аюулд орж, сурган хүмүүжүүлэгч нарын хүчирхийлэлд тодорхой хэмжээгээр өртдөг. Сүүлийн үед сурган хүмүүжүүлэгч багш нь шавьдаа гэмтэл учруулж, хүчирхийлэл үйлдэж байна. Гэвч багш нар шавьдаа гаргасан алдаа болгонд мөнгөн торгууль төлөх эсвэл

ажлаасаа чөлөөлөгдөөд л өнгөрч байна. Гэвч цаана нь сурагчид эрүүл мэнд болон насаараа сэтгэлийн шархтай болж үлддэг.

Үгээр үхүүлэгч багш

Намайг наймдугаар ангид байхад ахлах ангийн математикийн багш хүүхэд болгоноос мөрөөдөл чинь юу вэ гэж асуусан юм. Хүүхэд болгон мөрөөдлөө хэллээ. Миний ээлж ирэхэд “би цагдаа болно” гэж товхийтэл хариулсан. Гэтэл тэр багш “би чамайг цагдаа болно гэж бодохгүй байна. Чи чадахгүй ээ” гэж хэлж байсан нь одоо хэр санаанаас гардаггүй. Тэр үед би зүгээр л ангийнхнаасаа ичиж, үхмээр бас уйлмаар байсан ч нулимсаа тэвчин хичээлийн цагийг дуусгасан. Харин би цагдаа болох мөрөөдлөө үүрд орхисон юм.

Уг нь хүүхэд бүр тэгш эрхтэй гэж яригддаг ч энэ нь багш нарын хувьд хэрэгждэггүй. ЕБС-ийн сурагчдын дунд сурлагын дүнгээс болж багш нартайгаа үл ойлголцох асуудал гардаг. Дүнгээр ялгаварласнаас анги дотроо сайн муу гэж нэгнийгээ гадуурхах эхлэл тавигддаг. Ихэнхдээ багш нар сурагчдад цаг зав гаргах нь бага. Сурагч нь даалгавраа хийгээгүй эсвэл хичээл дээр ярьж, үймүүлэхэд багш орилж, олон хүүхдүүдийн дунд доромжилж, хэлэх хэлэхгүй үг хэлж хүүхдийн өөртөө итгэх итгэл, өөрийнх нь үнэ цэнийг үгүй хийж, хичээл номондоо дур сонирхолгүй болгоход нөлөөлдөг.

Оюутан Г.Маргад-Эрдэнэ “Би Архангай аймгийн Өгий нуур сумын 10 жилийг төгссөн. Би бага ангийн багшдаа их гомддог. Дөнгөж нэгдүгээр ангид орж байхад багш эмээд минь “Үсгээ мэддэггүй наад мангар хүүхдээ аваад манай сургуулиас зайл” гэж байсан нь одоог хүртэл тодхон санагддаг” гэж ярьсан юм. Багш гэдэг хүн ямар ч нөхцөлд сэтгэл хөдлөлөө хянан сурагчтайгаа зөв зохистой харилцаж, асуудлыг зөвөөр шийддэг болох хэрэгтэй.

Хувиараа бизнес эрхэлдэг М.Хулан Баянхонгор аймгийн гуравдугаарыг сургуулийг төгсчээ. Тэрээр, “Монгол хэлний багш маань хүүхэд ялгаварладаг байсан юм. Би монгол хэлэндээ жаахан муу, хичээл хоцрогдолтой хүүхэд байсан юм л даа. Нэг өдөр сургууль дээр монгол бичгийн "сайхан бичиг" уралдаан зарлагдав. Би оролцох гээд багшдаа хэлтэл чи оролцох хэрэггүй гэсэн. Бас 12 дугаар ангидаа "Жүжигчин болно" гэж багшдаа хэлсэн боловч монгол хэлний багш

маань чи чадахгүй гэж миний урмыг мохоосноос хойш би мөрөөдлөө хаясан” гэж ярьсан юм.

"Үйлдлээс илүү үг хатуу" гэж үг ч байдаг. Үгээр хүнийг амьдруулж ч болно, үхүүлж болно гэдэг үг ч бас бий. Хүний сэтгэл зүйд нөлөөлөх хүчин зэвсгийн нэг бол үг. Ер нь том жижиггүй л магтуулах дуртай. Магтаал сайшаалын үгийг шавь нар нь багшаасаа үргэлж сонсохыг хүсдэг. Багшаасаа л ганцхан үг хүлээдэг. Сонсох л юм бол энэ хорвоогийн хамгийн сайн хүн болчих юм шиг, цаашдаа хичээж, өөртөө итгэлтэй болох гээд байгаа ч юм шиг. Хүүхдийн тэр сайхан сэтгэлд хар бараан дурсамж үлдээвэл тэр насан туршийн арилахгүй хар толбо болж үлдэнэ. Хүний амьдралын хамгийн мартагдашгүй бас давтагдашгүй үе бол хүүхэд нас. Хүүхэд болгон багшаасаа хайр хүсч, намайг ч бас ялгаварлалгүй, ад үзэхгүй харьцдаг байгаасай. Багш минь намайг ганцхан удаа мартчихаасай гэж маш их хүсдэг. Магтаал сайшаалын ганц хоёрхон үг ч гэсэн хэчнээн аз жаргалтай болгодгийг хүн бүр л мэднэ. "Шавьтай багш гэдэг ундрагатай булаг" гэж хэлэлцдэг. Багш гэдэг хүн бол сурагчдынхаа бахархал болж явах ёстой хүн юм. Одоо харин бахархал биш, үзэн яддаг хүн нь болж байна. "Багш" гэдэг хүн битгий ийм байгаасай. Хүүхдэд ер нь бол багшийн хэлж буй үг эцэг эхийн үгнээс ч хүнд тусдаг гэдгийг санаж яваасай.

Ялгаварлагч багш

Би математикийн хичээлдээ тааруу байсан. Тийм болохоор манай математикийн багш надад тоож хичээл заадаггүй, миний хийсэн даалгаврыг тогтож шалгадаггүй байсан юм. Тэгээд л би дургүй дээрээ бүр дургүй болж математикийг амьдралаасаа хассан даа. Багш нар ийн сурагчдаа сурлагын дүнгээр нь ялгаварлан гадуурхдаг. Хичээлдээ сайн хүүхдүүдтэй илүү сайн харилцаж, тухайн хичээлийг нь ойлгохгүй, хоцрогдолтой байгаа хүүхдүүдийг тоодоггүй.

Хэрэв би нэг хичээлд тааруухан байлаа гэхэд бусад хичээлд автоматаар муу үнэлгээ өгдөг. Үүнд миний хичээл зүтгэл, идэвх санаачилга огтоос хамаагүй. Хэзээ ч сайн үнэлгээ өгнө гэж найдах хэрэггүй. Багшдаа итгэх ч хэрэггүй. Тэгээд л сурагчид тухайн хичээлд суралцах сонирхолгүй болж, урам нь хугардаг. Ингээд л багшдаа дургүй болж, дургүй багшийнхаа хичээлд суухыг ч хүсдэггүй.

Багш нар зүгээр л цалин авахын төлөө ажлаа хийдэг. Гэтэл багш хүүхдийн авьяас чадварыг нээн дэлгэрүүлж, хүүхдэд хүн болох арга ухаан, хүнийг хайрлах сэтгэл, хүнийг хүндлэх, хүн болох эхлэлийг тавьдаг гэж би боддог. Миний хувьд бүтэн 12 жилийн туршид үл хайхрах хүчирхийлэл дор ангийн багшийн ялгаварлан гадуурхалтыг даван туулж, хажуугаар нь сурч боловсрох хүнд өдрүүдийг туулсан. Энэ зөвхөн надад тохиолдсон зүйл биш. Олон мянган хүүхдүүдэд бас тохиолддог.

Харамсалтай нь өнөөгийн багш нар ийм байж чаддаггүй. Тухайлбал, хүүхдийг сайн таниагүй, мэдээгүй атлаа энэ хүүхэд хичээлдээ сайн байх эсвэл муу байх гэсэн анхны сэтгэгдлээр хүүхдэд хандах нь элбэг харагддаг. Эсвэл хүүхдийг ар гэрийн амьдрал, гаргаж буй зан араншин, үйл хөдлөлөөс нь болж сайн муугаар ялган хандах тохиолдол ихэнхдээ байдаг.

Эрдэнэтийн 4 дүгээр сургуулийг төгсөгч М.Анхзаяа багшийнхаа тухай “Би одоо энэ талаар нэг их яриад байхыг хүсдэггүй юм. Би гэхдээ багш хүнд итгэхээ больсон. Манайх ам бүл олуулаа, амьдралын бололцоо тааруу айл байсан л даа. Бид нар хувцас хунар тааруу байсан нь үнэн. Тэр үед миний сэтгэл зүй маш муу, яг л үхмээр санагддаг байсан үе. Тийм хүнд ар гэрийн асуудал дээр багшийн гадуурхал их бас нөлөөлдөг байсан. Хэзээ ч ангийн багш маань надтай нүүр тулж харьцаж үзээгүй. Ийм хэцүү үед багш маань надаас “чи зүгээр үү?” гээд яагаад асуучихаагүй юм бол оо? гэж одоо боддог. Гэхдээ би одоо ажилтай, амьдралтай, карьертай сайн л явж байгаа л даа” гэлээ.

Ер нь бол муу хүүхдүүд ангидаа хойгуур суудаг, эсвэл сайн хүүхдүүд урдуур суудаг жишиг өнөөдөр манай Монголд хэвийн үзэгдэл болсон байна. Энэ ялгаварлын хамгийн том жишээ.

Авилгач багш

2014 он. Намайг долоодугаар ангид байхад багш нарын баяр болох дөхөв. Манай ангийнхан ч цуглаж хоорондоо мөнгөө цуглуулаад багшдаа өвлийн малгай, ороолт авч өгөх санал дундаасаа гаргасан. Энэ талаараа багшдаа цухуйлгав. Тэгсэн манай ангийн багш миний толгой жаахан том, тийм учраас хэр баргийн малгай ордоггүй юм. Мөнгийг нь өгчих. Би өөрөө авна гэж билээ. Хүүхдүүд л юм хойно сэтгэлээсээ бэлэг нийлж авч өгөх гэж байгаад ийм үг сонссондоо тухайн үед жаахан сонин

санагдаж шивэр авир болоод л өнгөрсөн. Багшийгаа л ийм юм байх гэсэн ийм ардын багш нар олширсон бололтой. Ер нь бол цэцэрлэгийн багачуудаас авхуулаад ЕБС-ийн сурагчид хүртэл баяр нь дуусашгүй. Жишээ нь, цэцэрлэг төгссөний баяр, цагаан толгойн баяр, хонхны баяр, бас болоогүй эмэгтэйчүүдийн баяр, цэргийн баяр, сургуулийн ой гээд л татаас нь мөддөө дуусахгүй. Энэ мэт баярын халхавчаар цэцэрлэгийн хүмүүжигч багачуудаас эхлэн сурагч, оюутнууд багшдаа заавал бэлэг авч өгнө. Тэр бэлэг нь зүгээр 10-20 мянган төгрөгийн чихэр, архи, дарс биш. Бусад ангиас давсан бэлгийг багшдаа өгөх гэж багахан хэмжээний уралдаан өрнүүлэх нь холгүй. Дараа нь багш нар хоорондоо ярьдаг юм гэсэн. Энэ бас болоогүй ээ, багш нар нь бэлгээ өөрөө сонгоод захиалчихдаг гээд л бод. Саяхан 5-р лсургуулийн багш сурагчдаасаа үнэтэй гар утас, хоолны сав нэхсэнийг бид нүүр хуудаснаас харж баахан гайхширсан. Ийм жишээг бараг Монголын сурагч бүр л хэлэх байх.

Оюутан Н хэлэхдээ, “Манай анги олон жилийн дараа уулзах болоод ангийн багшдаа нийлж бэлэг авч өгөх гээд холбогдсон чинь багшдаа зүгээр мөнгийг нь өгчих гээд чичрээд байсныг нь яана. Маргааш нь бид ангиараа нийлээд хэдэн зүйлс гэрт нь аваад очсон чинь энэ бүгд чинь надад хэрэггүй, шуудхан л мөнгө өг гээд байсан. Аягүй инээдтэй, улаан цагаандаа гарчихсан санагдсан” гэж хэлэв.

Энэ мэт бэлэг нэрээр "авилга" гэгчийг цэцэрлэгээс эхлүүлэн, дунд сургууль, коллеж, их дээд сургууль хүртэл цэцэглэн мандуулж байна. Багш нар маань хүмүүжүүлж байгаа сурагчдаа бусдад авилга, хээл хахууль, бэлэг өгөхийг зааж сургаад бусдын гарыг цайлгахгүй л бол ажил урагшлахгүй, үнэлэгдэхгүй гэдэг сэтгэлгээг бидэнд суулгаж байна.

Багшийн тухай дүгнэхэд

Багш гэдэг эрхэм хүн хүүхдийн цав цагаахан сэтгэлд хар дурсамж болж битгий үлдээсэй хэмээн энэ нийтлэлээрээ дуу хоолой болж байна.

Өнөөдөр багш нарын ёс зүй хэвийн биш гэдгийг эцэг эхчүүдийн дундах “хүүхдээ сайн багшийн ангид өгөх тухай яриа” яриан нотолно. Сошиал хуудсаар гарч буй сурагчдаасаа гар утас, түмпэн сав, малгай ороолт гуйж буй багш нарын бичлэг, хүүхдүүдээ зодож буй зураг дүрс бас нотолно. Мөн боловсролын салбар

2022 оныг Ёс зүйн жил болгон зарласан нь давхар нотолгоо юм. 2021 онд багш, ажилтны ёс зүйн зөрчлийн талаарх 58 өргөдлийг аймаг, дүүргийн Ёс зүйн зөвлөлд ирж, олон албан хаагчдад шийтгэл ноогдуулснаас ийнхүү ёс зүйн жилийн зарлах болсон аж.

Багш бол өсвөр үеийнхний амьдарыг чиглүүлэгч луужин байх ёстой. "Хашийг эс засвал сав болохгүй, хүнийг эс засвал эрдэм сурахгүй" эсвэл "гэрээ засаад, төрөө зас" гэдэг ардын мэргэн үгс ч бий. Ийнхүү хүнийг залж засах үүрэг гагцхүү ганцхан багш гэдэг хүнд л оногдсон байдаг.

Монголын бүх багш нар ийм биш. Ажлаа чин сэтгэлээсээ хийдэг. Шавь нараа өөрийн хүүхдээс дутуугүй хайрлаж, ярилцдаг багш нар бий. Учир нь нэг үхрийн эвэр доргиход мянган үхрийн эвэр доргино гэдгийн тод жишээ нь энэ.

Багш хүн бүхий л талаараа хүүхдэд үлгэр дуурайлал болох ёстой. "Эх нь булингартай бол адаг нь булингартай" гэдэг зүйр үг бий. Ийм ч учраас багш нар ёс зүйтэй байж, шавь нартаа зөв үлгэр дуурайл болох хэрэгтэй.